




ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ



Зоонозын өвчний эрүүл мэндийн үзүүлэлт №18

Улаан баатар хот

2023 он

Өмнөх үг



*Зоонозын өвчин судлалын
үндэсний төвийн ерөнхий
захирал, Хүний гавьяат
эмч, дэд профессор, анагаах
ухааны доктор
Н.Цогбадрах*

Зоонозын Өвчин Судлалын Үндэсний Төвийн болон Аймаг, Нийслэлийн Зоонозын Өвчин Судлалын Төвүүдийн мэдээ, тайланд үндэслэн Зоонозын өвчний статистик мэдээллийн 18 дах удаагийн эмхэтгэлийн дугаарыг та бүхэнд хүргэж байна.

Коронавируст (КОВИД-19) халдвар нь дэлхийн өнцөг булан бүрт тархаж хүн амын эрүүл мэнд, улс орны нийгэм, эдийн засагт асар том хохирол учруулсан билээ. Бид энэхүү цар тахлын дараа дэлхий нийтээрээ хэвийн амьдралдаа эргэн орохыг эрэлхийлэхийн зэрэгцээ цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, түршлага, сургамж дээрээ суурилан зоонозын халдварын хүний эрүүл мэндэд учруулж буй аюул занал, эрсдэлийг хэрхэн бууруулах талаар бүрэн ойлголт мэдлэг, дадалтай болох зайлшгүй хэрэгтэй. Мөн ирээдүйд дахин цар тахал гарахаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй стратеги, бодлогын түвшинд хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллахад нөлөөлөх хүчин зүйлсийг ойлгох нь чухал юм. Цаашид хүн ам, ан амьтан, орчны эрүүл мэндийг сайжруулж, тодорхой үр дүнд хүрэхийн тулд нийгмийн эрүүл мэнд, амьтны эрүүл мэнд, ургамлын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин зэрэг олон салбарын мэргэжилтнүүдийг нэгтгэсэн “Нэг эрүүл мэнд”-ийн хандлагад суурилж хамтарч ажиллах нь чухал байна.

Хүн төрөлхтний дунд бүртгэгдэж буй халдварт өвчний 60 хувь, шинээр гарч буй бүх халдварт өвчний 75 хувь нь зоонозын гаралтай халдварт өвчин байна. Эбола, SARS, зика вирус, шувууны томүү гэсэн өвчнүүд амьтдаас хүнд халдварлаж ирсэн байдаг. Ирээдүйд зоонозын гаралтай шинэ өвчний дэгдэлтүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд тэдгээрийн үүсэх үндсэн шалтгааныг тодорхойлж, арилгах хэрэгтэй. Үүний тулд бидэнд салбар хоорондын хамтын ажиллагаа нэн чухал бөгөөд хариуцлага, зохион байгуулалтын тогтолцоог задлах, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийх, зэрлэг амьтдын ан агнуурыг зогсоохын тулд тогтвортой газар тариалан эрхлэх, газар нутаг, экосистемийн эрүүл мэндийг сэргээх, үүр амьсгалын өөрчлөлтийг бууруулах зэрэг бодлогын чанартай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол орны хувьд нүүдлийн амьдралтай ард түмэн бөгөөд мал, аж ахуй эрхэлж аж амьдралаа залгуулж амьдардаг уламжлалтай. Энэхүү замаар зоонозын өвчний халдвар авч өвчлөх, мөн гадаадын улс орнуудаас халдвар зөөвөрлөгдөн орж ирж халдвар тархах эрсдэл өндөр байдаг.

Монгол улсад 30 гаруй зоонозын халдварыг оношилж, бүртгэж байгаагаас 10 гаруй өвчин жил бүр тогтмол бүртгэгдэж байна. 2022 онд зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй 685, амьтны 206 дуудлага бүртгэгдсэн байна. Хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол 685 бүртгэгдсэн нь өмнөх оноос 1.2 дахин нэмэгдэж, сүүлийн 5 жилийн дунджаас 35 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт бүртгэгдсэн зоонозын өвчний сэжигтэй тохиолдлын

дуудлагын 153 буюу 22% нь лаборатори болон тархвар судлалаар онош батлагдсан байна. Энэ онд нийт 7 төрлийн өвчин батлагдсан бөгөөд нийт өвчлөлийн 80 хувийг хачигт риккетсиоз, 11 хувийг хачигт боррелиоз, 5 хувийг хачигт энцефалит, тарваган тахал, боом, хумхаа, ям өвчнүүд тус тус эзэлж байна.

Энэхүү эмхэтгэлийг бид жил бүр эрхлэн гаргадаг бөгөөд энэ удаагийн эмхэтгэл нь нийт 3 бүлэг 33 хүснэгт, 45 зургаар илэрхийлэн зоонозын халдварт өвчний статистик мэдээллийг агуулсан. Тус эмхэтгэл нь зоонозын салбарын мэргэжилтэн, судлаачид эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, зоонозын халдварт өвчний үеийн хариу арга хэмжээг зохион байгуулах зэрэгт нотолгоонд суурилсан шинжлэх ухаанч дүгнэлт гаргахад үндсэн суурь мэдээлэл болгон ашиглагдах ач холбогдол бүхий мэдээлэл болно гэдэгт итгэж байна.

Энэхүү эмхэтгэлийг хамтран боловсруулсан Зоонозын өвчин судлалын нийт хамт олондоо талархал илэрхийлье.



ЕРӨНХИЙ РЕДАКТОР

Н.Цогбадрах, Ерөнхий захирал, МУ-ын Хүний гавьяат эмч, Дэд профессор, Анагаах ухааны доктор

ХЯНАН ТОХИОЛДУУЛАСАН

Д.Алтантогтох, ЭШСМТА-ны дарга, Биологын ухааны магистр

ЭМХЭТГЭСЭН

О.Даариймаа, Статистикч, магистрант

МЭДЭЭЛЛИЙГ БЭЛТГЭСЭН

1. Э.Пагмадулам, А.Эрдэнэцэцэг Хүний нөөцийн мэдээлэл
2. О.Даариймаа Зоонозын хүний өвчний мэдээлэл, статистик боловсруулалт
3. Б.Байгалмаа, Ч.Буянхишиг Нэгдсэн лабораторийн үйл ажиллагаа
4. Х.Цэрэнсүрэн, Д.Мөнх-Эрдэнэ Ариутгал халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа
5. Л.Роломжав, Зоонозын өвчний дархлаажуулалт
7. Ц.Отгонцэцэг, Холер өвчний хяналт шинжилгээний мэдээлэл
8. Ц.Ганхуяг, Д.Батжав Тарваган тахал өвчний байгалийн голомтын мэдээлэл
9. Х.Бурмаа, Боомын өвчлөл, голомт, хяналтын мэдээлэл
10. Ж.Батцэцэг, Хачгаар дамжих халдварын байгалийн голомтын мэдээлэл
11. Б.Болор, Шумуулаар дамжих халдварын мэдээлэл
12. С.Мөнгөнбагана, Шувууны томуугийн мэдээлэл
13. Б.Чимэдциеэ, Сургалт, сурталчилгааны мэдээлэл
14. Ш.Сувд-эрдэнэ, Галзуу өвчний мэдээлэл
15. П.Алтангэрэл, Сургалтын мэдээлэл
16. Ц.Баяр, Эрдэм шинжилгээний мэдээлэл
17. Д.Алтантогтох, Тархалтын зураг
18. Б.Болорчимэг, Галзуугийн малын өвчлөл, мэрэгчийн дуудлагын мэдээлэл
19. Б.Өлзийжаргал, Цахим хуудасны мэдээлэл

Энэхүү эмхэтгэлийн талаар саналыг дараах хаягаар ирүүлнэ үү.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг 20 дугаар хороо

Шуудангийн хаяг: 18131

Факс +976 70282859

Утас +976 70282859

ГАРЧИГ

БҮЛЭГ НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
1.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ; 2022.....	4
1.2. МОНГОЛ УЛСЫН МАЛЫН ТОО; 2022	5
1.3. ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦ; 2022	6
БҮЛЭГ ХОЁР. ЗООНОЗЫН ӨВЧНИЙ МЭДЭЭЛЭЛ.....	11
2.1. ЗООНОЗЫН ХАЛДВАРЫН ХҮНИЙ ӨВЧЛӨЛИЙН ДУУДЛАГА; 2022.....	11
2.1.1. Халдварт өвчин.....	12
2.1.2. Зоонозын халдварын хүний өвчлөлийн дуудлага	13
2.2. МЭРЭГЧ АМЬТНЫ ДУУДЛАГА; 2022	15
2.3. ЗООНОЗЫН ӨВЧНИЙ ХҮНИЙ ӨВЧЛӨЛИЙН МЭДЭЭЛЭЛ; 2022	16
2.3.1. Зоонозын халдварын хүний өвчлөлийн мэдээлэл	16
2.3.2. Тарваган тахал	20
2.3.3. Боом	25
2.3.4. Хачгаар дамжих халдвар	29
2.3.5. Галзуу өвчний мэдээлэл	36
2.3.6. Хумхаа	39
2.3.7. Холер	40
2.3.8. Бэтэг.....	43
2.3.9. Коронавируст халдвар	44
2.3.10. Бруцёллоз	45
2.3.11. Ям.....	46
2.3.12. Шувууны томуу	47
2.3.13. Шумуулаар дамжих халдвар.....	52
БҮЛЭГ ГУРАВ. ЛАБОРАТОРИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ	54
3.1. ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ; 2022	54
3.2. АРИУТГАЛ ХАЛДВАРГУЙЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА; 2022.....	57
БҮЛЭГ ДӨРӨВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА	60
4.1. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА; 2022	60
4.1.1. Эмнэлгийн мэргэжилтний сургалт	60
4.1.2. Олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгаа	62
4.1.3. Фэйсбүүк пэйж хуудасны мэдээ, мэдээлэл.....	64
4.1.4. Эрүүл мэндийн байгууллагуудад зохион байгуулсан сургалт	64

ЗУРГИЙН ТАЙЛБАР

Зураг 1. Нийслэл, аймгийн зоонозын өвчин судлалын төвүүд байгуулагдсан оноор	6
Зураг 2. Зоонозын өвчин судлах байгууллагуудын хүний нөөц 2022 он	7
Зураг 3. Зоонозын өвчин судлах байгууллагын ажиллах хүч насны ангиллаар	9
Зураг 4. ЗӨСҮТ-ийн эрдмийн зэргийн үзүүлэлт сүүлийн таван жилийн байдлаар	9
Зураг 5. Эрдэм шинжилгээний ажлын тоон үзүүлэлт /сүүлийн 5 жилээр/.....	10
Зураг 6. Халдварт өвчний нас баралт, төрлөөр.....	12
Зураг 7. Зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол, 2022 он	13
Зураг 8. Мэрэгчийн дуудлага, нэгж материал (Сүүлийн 5 жилээр).....	15
Зураг 9. Мэрэгчийн дуудлага, аймгаар, 2022 он.....	15
Зураг 10. Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол, өвчлөл, нас баралт (сүүлийн 5 жилээр)	18
Зураг 11. Зоонозын өвчний сэжигтэй батлагдсан тохиолдол 10 000 хүн амд аймгаар.....	18
Зураг 12. Тарваган тахлын хүний өвчлөл (сүүлийн 10 жилийн байдлаар)	20
Зураг 13. Тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээнд хамрагдсан аймаг, сумдаар	22
Зураг 14. Тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээ	22
Зураг 15. Мэрэгч амьтдын нягтшил 1 га-д.....	23
Зураг 16. Шинжилсэн гадны шимэгч.....	23
Зураг 17. Шинжилсэн мэрэгч	23
Зураг 18. Тарваган тахлын өсгөвөр илэрэлт (сүүлийн 10 жилээр).....	24
Зураг 19. Тарваган тахлын дархлаажуулалт 2012-2022 он.....	24
Зураг 20. Малын боом өвчний гаралт 2022 он эхний хагас жилээр.....	25
Зураг 21. Монгол улсад малын боом өвчний дархлаажуулалт 2022 он.....	25
Зураг 22. Хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт сэжигтэй дуудлагын тоо (2018-2022).....	26
Зураг 23. Боомын хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт сэжигтэй дуудлагын тоо(2000-2022)	26
Зураг 24. Боомын хүн, малын өвчлөлийн тохиолдол (Сүүлийн 10 жилээр).....	27
Зураг 25. Шинжилгээнд дээжилтсэн сорьцын тоо аймгаар.....	27
Зураг 26. Тандалт судалгаанд хамрагдсан газрууд 2022 он	29
Зураг 27. Хачигт халдварын эпидемиологийн 7 хоног	30
Зураг 28. Хачигт энцефалитийн хүний өвчлөлийн тархалт 2022 он	31
Зураг 29. Хачигт энцефалитын дархлаажуулалт 2005-2022 он.....	33
Зураг 30. Галзүү өвчний мал, амьтны өвчлөлийн тархалт 2022 он	36
Зураг 31. Галзүү өвчний гаралт малын төрлөө (2022 оны МЭЭГ-ын мэдээгээр)	36
Зураг 32. Галзүүгийн хүний өвчлөл эпидемиологийн долоо хоногоор	37
Зураг 33. Галзүүгийн вакцинд хамрагдсан 2005-2022 он.....	38
Зураг 34. Холерын хяналтын шинжилгээнд цуглуулсан материал (төрлөөр)	41
Зураг 35. Шумуулын тандалтын 5 жилийн дунджийг 2022 оны тандалттай харьцуулсан байдал	53
Зураг 36. 3 Лабораторийн оношилгоо, шинжилгээний тоон үзүүлэл (Сүүлийн 10 жилээр).....	54
Зураг 37. Ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг өмнөх 5 жилийн үзүүлэлттэй харьцуулсан байдал	58
Зураг 38. ЗӨСТ-үүдэд нийлүүлсэн тэжээлт орчин 2022 он	59
Зураг 39. Сүүлийн 5 жилд үйлдвэрлэсэн үндсэн, ялган оношлох, будаг, урвалж, уусмалын хэмжээг харьцуулсан үзүүлэлт	59
Зураг 40. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн сургалт (2022 он)	60
Зураг 41. Эмч эмнэлгийн сургалт төрлөөр /Сүүлийн 3 жил/	61
Зураг 42. Үндсэн мэргэшилээр суралцагчдын тоо ЗӨСТ-тэй аймгаар /Сүүлийн 5 жил/.....	61
Зураг 43. Үндсэн мэргэшилээр суралцагчдын тоо ЗӨСТ-гүй аймгаар	62
Зураг 44. Аймаг, нийслэлийн ЗӨСТ-ийн мэдээ нийтлүүлсэн байдал	62
Зураг 45. ЗӨСҮТ-ийн нийтэдсэн мэдээ алба, тасгаар	63

ХҮСНЭГИЙН ТАЙЛБАР

Хүснэгт 1. Монгол улсын хүн амын тоо сүүлийн 5 жилийн байдлаар	4
Хүснэгт 2. Монгол улсын малын тоо сүүлийн таван жилийн байдлаар	5
Хүснэгт 3. Хүний нөөцийн тоон үзүүлэлт аймаг, албан тушаалаар /2022/	8
Хүснэгт 4. Халдварт өвчний тохиолдол нас баралт, төрлөөр	12
Хүснэгт 5. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоог харьцуулсан үзүүлэлт сүүлийн 5 жилээр	14
Хүснэгт 6. 2022 онд бүртгэгдсэн зоонозын өвчний төрлөөр, аймгаар	17
Хүснэгт 7. Зоонозын өвчлөл 10 000 хүн амд (Сүүлийн 5 жилээр)	19
Хүснэгт 8. Тарваган тахлын батлагдсан тохиолдол, нас баралт, нас баралтын хувь (1970-2022 он)	20
Хүснэгт 9. Тарваган тахал өвчний өвчлөл, нас баралтын түвшин /2021-2022/	21
Хүснэгт 10. Боомын хүний өвчлөл, нас баралтын түвшин /2021-2022/	28
Хүснэгт 11. Хачгаар дамжих өвчний тандалт шинжилгээнд хамрагдсан байдал	29
Хүснэгт 12. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй дуудлага (төрлөөр)	30
Хүснэгт 13. Хачигт энцефалит өвчний хүний өвчлөл, нас баралтын түвшин/2021-2022/	32
Хүснэгт 14. Хачигт риккетсиоз өвчний хүний өвчлөл, нас баралтын түвшин /2021-2022/	34
Хүснэгт 15. Хачигт боррелиоз өвчний хүний өвчлөл, нас баралтын түвшин/2021-2022/	35
Хүснэгт 16. Галзуу өвчний өвчлөл, нас баралт 10 000 хүн тутамд /2021-2022/	37
Хүснэгт 17. Хумхаа өвчний өвчлөл нас баралтын түвшин, 10 000 хүн тутамд /2021-2022/	39
Хүснэгт 18. Холер өвчний өвчлөл нас баралтын түвшин /2021-2022/	40
Хүснэгт 19. Холерын хяналтын шинжилгээнд цуглуулан шинжилсэн сорьцын мэдээлэл	41
Хүснэгт 20. Холерийн хяналтын шинжилгээний харьцуулсан үзүүлэлт	42
Хүснэгт 21. Бэтгийн хүний өвчлөл, нас баралтын түвшин /2021-2022/	43
Хүснэгт 22. COVID-19 Коронавируст халдварын өвчлөл, нас баралтын түвшин /2020-2021/	44
Хүснэгт 23. Бруцеллёзийн хүний өвчлөл, нас баралтын түвшин /2021-2022/	45
Хүснэгт 24. Ямийн өвчлөл, нас баралтын түвшин /2021-2022/	46
Хүснэгт 25. Шувууны томуугаар үүсгэгдсэн хүний өвчлөлийн мэдээлэл	47
Хүснэгт 26. Шувууны томуугийн тандалт судалгааны нэгдсэн дүн	49
Хүснэгт 27. Шувууны томуугаар Монгол орны хэмжээнд хэрэгжсэн төслүүд 2022 он	50
Хүснэгт 28. Шумуулын тандалт сүүлийн 5 жилээр	52
Хүснэгт 29. Зоонозын өвчний нэр төрөл сорьцын тоо (2022)	55
Хүснэгт 30. Лабораторийн шинжилгээ хийсэн арга /сүүлийн 3 жилээр/	56
Хүснэгт 31. Ариутгал халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулсан байдал	57
Хүснэгт 32. 2017-2022 оны биоүйлдвэрлэлийн лабораторид үйлдвэрлэсэн биобэлдмэлийн тоон үзүүлэлт	58
Хүснэгт 33. Сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа 2022 он	65

БҮЛЭГ НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ; 2022

Монгол улсад 2022 оны байдлаар 3,457,548 хүн амтай байгаа нь байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 1.4 хувиар өссөн байна. Мөн нийт хүн амын 1,696,148 буюу 49 хувь нь эрэгтэй 1,761,400 буюу 51 хувийг эмэгтэйчүүд эзэлж, хүйсийн харьцаа тэнцүү байна.

Хүн амын тоог бүс нутгаар харьцуулж үзэхэд хангайн бүс хамгийн өндөр 603,427 байгаа бол аймгуудаар харьцуулж үзэхэд 7.7 хувь буюу 136,633 хамгийн өндөр, 1 хувь 18,007 хамгийн бага хүн амтай байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Монгол улсын хүн амын тоо сүүлийн 5 жилийн байдлаар

Аймаг Улсын дүн	2018	2019	2020	2021	2022
Баруун бүс	408,979.	412,036.	415,091.	418,607	418,607
Баян-Өлгий	105,090.	108,530.	110,597.	112,836	114,776
Говь-Алтай	58,471.	57,748.	57,674.	57,818	57,098
Завхан	72,779.	72,823.	72,763.	72,731	71,798
Увс	84,309.	83,223.	83,524.	84,095	83,964
Ховд	88,330.	89,712.	90,533.	91,127	91,071
Хангайн бүс	604,353.	605,216.	604,200.	606,430	603,427
Архангай	96,720.	94,994.	94,088.	94,205	93,149
Баянхонгор	88,356.	88,672.	88,955.	89,043	88,397
Булган	62,214.	62,089.	61,955.	61,943	61,161
Орхон	105,987.	107,634.	107,765.	108,713	109,125
Өвөрхангай	117,112.	116,732.	115,732.	115,732	114,962
Хөвсгөл	133,964.	135,095.	135,705.	136,794	136,633
Төвийн бүс	513,438.	516,611.	515,880.	518,344	515,771
Говьсүмбэр	17,796.	17,928.	17,965.	18,150	18,007
Дархан-Уул	105,923.	107,018.	106,909.	107,751	107,932
Дорноговь	69,304.	71,014.	71,207.	71,720	71,129
Дундговь	46,628.	47,104.	46,981.	46,920	46,387
Өмнөговь	66,722.	69,187.	70,371.	71,720	72,937
Сэлэнгэ	111,403.	110,110.	109,285.	108,878	107,341
Төв	95,662.	94,250.	93,162.	93,468	92,038
Зүүн бүс	220,334.	223,193.	225,081.	227,386	227,877
Дорнод	80,984.	82,054.	83,087.	83,757	83,704
Сүхбаатар	62,322.	63,182.	63,822.	64,662	65,214
Хэнтий	77,028.	77,957.	78,172.	78,967	78,959
Улаанбаатар	1,491,375.	1,539,810.	1,597,290.	1,639,172	1,691,766

1.2. МОНГОЛ УЛСЫН МАЛЫН ТОО; 2022

Монгол улсад 2022 оны жилийн эцсийн байдлаар малын тоо 71,120.43 мянган толгой болж, өмнөх оныхоос 3.8 сая толгой буюу 5.9 хувиар өссөн байна. Үүнээс адуу 6.7% буюу 4.8 сая, үхэр 7.7% буюу 5.5 сая, тэмээ 0.7 хувь буюу 470.4 мянга, хонь 46% буюу 32.7 сая, ямаа 39% буюу 27.5 сая тоо толгойг тус тус эзэлж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Монгол улсын малын тоо сүүлийн таван жилийн байдлаар


Нэгж	2018	2019	2020	2021	2022
Улсын дүн	66,460,180	70,949,315	67,068.49	67,343.76	71,120.43
Баруун бүс	15,557,380	16,004,300	15,845.18	16,448.05	16,131.03
Завхан	3,555,410	3,849,910	3,607.84	3,755.16	3,721.06
Говь-Алтай	3,513,370	3,597,700	3,310.83	2,990.51	3,167.47
Баян-Өлгий	2,166,920	2,192,760	2,224.68	2,379.01	2,255.81
Ховд	3,146,410	3,084,330	3,292.58	3,596.97	3,472.85
Увс	3,175,280	3,279,600	3,409.25	3,726.4	3,513.85
Хангайн бүс	24,323,006	26,246,450	22,752.39	22,432.04	24,511.95
Орхон	114,350	126,950	136.99	154.58	169.94
Өвөрхангай	5,461,350	5,625,460	4,479.06	4,022.69	4,589.39
Булган	3,305,50	3,644,610	3,395.98	3,622.25	3,892.84
Баянхонгор	4,249,470	4,644,870	3,839.88	3,127.12	3,719.59
Архангай	5,482,030	6,167,040	5,399.93	5,562.17	5,886.09
Хөвсгөл	5,710,370	6,040,430	5,500.55	5,943.21	6,254.1
Төвийн бүс	15,428,46	16,958,68	16,691.04	15,811.38	16,970.94
Төв	4,582.44	4,979.16	4,887.52	4,746.04	5,107.7
Говьсүмбэр	427,46	452	451	432.2	464.29
Сэлэнгэ	1,540,04	1,682.49	1,818.52	1,886.74	1,912.34
Дорноговь	2,148,13	2,404,25	2,551.55	2,706.8	2,909.7
Дархан-Уул	306,01	347,35	360.57	335.33	313.21
Өмнөговь	2,598.44	3,000.3	2,880.77	2,513.81	2,637.33
Дундговь	3,825.94	4,093.12	3,741.11	3,170.48	3,626.37
Зүүн бүс	10,739.5	11,314.99	11,311.19	12,208.97	13,063.67
Дорнод	2,377,78	2,629,62	2,749.68	3,051.07	3,342.32
Сүхбаатар	3,716.81	3,817.01	3,893.63	4,202.94	4,664.8
Хэнтий	4,644,91	4,868,36	4,667.89	4,954.96	5,076.55
Улаанбаатар	411.78	444.89	468.69	443.32	442.84

1.3. ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦ; 2022

Улсын хэмжээнд зоонозын өвчин судлах чиглэлээр 15 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь Улаанбаатар хотод 1931 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа бол орон нутагт хамгийн анх 1937 онд Завхан аймагт, хамгийн сүүлд 2004 онд Сэлэнгэ аймагт тус тус Зоонозын өвчин судлалын төв байгуулагдаж байжээ.

Монгол улс нь нүүдлийн аж амьдралтай бөгөөд өдөр тутамдаа мал, амьтантай харьцах замаар орон нутгийн иргэд зоонозын халдвараар өвчлөх өндөр эрсдэлтэй хүн амд хамаардаг. Иймээс цаашид зоонозын өвчин судлах байгууллагагүй Булган, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгуудад зоонозын өвчин судлалын төвийг шинээр байгуулах хэрэгцээ шаардлага өндөр байна (Зураг 1).

Зураг 1. Нийслэл, аймгийн зоонозын өвчин судлалын төвүүд байгуулагдсан оноор




Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймаг нийслэлийн зоонозын өвчин судлалын төвүүдийн батлагдсан эрх зүйн баримт бичгийн дагуу алба, тасгийн зохион байгуулалттайгаар хүний нөөцийн

үйл ажиллаг зохион байгуулан ажиллаж байна. Зоонозын өвчин судлах байгууллагад нийтдээ 409 албан хаагч батлагдсан орон тооноос 2022 оны байдлаар 400 буюу 98 хувь нь ажиллаж байна.

Зоонозын салбарт ажиллаж буй мэргэжилтнүүдийн албан тушаалаар харьцуулж үзэхэд 17.5 хувь нь эмч, 28 хувь нь бусад дээд мэргэжилтэн, 24.3 хувь нь эмнэлгийн туслах ажилтан, 12.5 хувь нь лаборант, 13.7 хувь нь бусад эмнэлгийн мэргэжилтэн, удирдлага 4

хувийг тус тус эзэлж байна. Үүнээс харахад зоонозын өвчин судлах байгууллагуудад эмч, эмнэлгийн мэргэжилтнээс гадна бусад салбарын дээд мэргэжилтнүүд ажиллаж байдаг нь бусад эрүүл мэндийн салбаруудаас онцлогтой байна (Зураг 2).

Зураг 2. Зоонозын өвчин судлах байгууллагуудын хүний нөөц 2022 он



Зоонозын өвчин судлах байгууллагын хүний нөөцийн мэдээллийг аймгаар харьцуулж үзэхэд орон нутгууд 93.3 хувьтайгаар орон тоогоороо ажиллаж байна. Үүнээс хамгийн өндөр орон

тоогоор Хэнтий аймаг ажиллаж байгаа бол хамгийн бага орон тоогоор Төв аймаг ажиллаж байна (Хүснэгт 3).


Хүснэгт 3. Хүний нөөцийн тоон үзүүлэлт аймаг, албан тушаалаар /2022/

Үзүүлэлт		Баян-Өлгий	Хөвсгөл	Сэлэнгэ	Увс	Өвөрхангай	Завхан	Багануур	Архангай	Говь-Алтай	Хэнтий	Ховд	Баянхонгор	Өмнөговь	Дундговь	Төв аймаг	ЗӨСҮТ
Эмч	Удирдлага	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	2
	Халдвар судлагч	2	2	0	2	0	1	0	0	0	0	2	2	1	0	1	0
	Тархвар судлагч	0	0	1	0	1	0	0	2	1	0	0	0	0	0	2	12
	Нян судлагч	2	1	1	1	1	1	0	0	2	2	2	3	2	0	0	10
	Лабораторийн	0	0	0	1	0	0	1	2	0	2	0	0	0	1	0	0
	Вирус судлагч	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
	Бусад /төрөлжсөн мэргэжлээр нэмж болно/	4	3	2	5	3	2	1	4	3	4	4	5	3	1	3	23
Бусад дээд мэргэжилтэн	Амьтан судлагч	2	3	1	2	1	1	1	1	1	1	3	1	1	0	0	5
	Шимэгч судлагч	1	1	1	1	1	1	1	1	1	1	2	1	1	0	0	3
	Нянгийн генетикч	0	0	0	0	0	0	0	1	0	0	1	0	0	0	0	3
	Мэдээлэл технологийн ажилтан	0	0	0	0	0	0	1	0	0	1	0	1	0	0	0	2
	Бусад /мэргэжлээр нэмж болно/	2	1	1	2	4	2	6	2	1	3	3	4	1	1	2	26
	Амьтан судлагч	5	5	3	5	6	4	9	5	3	6	9	7	3	1	2	39
Лаборант	Нян судлал	1	1	1	2	2	2	0	1	2	1	4	2	0	0	0	5
	Амьтан судлал	1	1	0	0	1	1	0	0	1	1	0	1	1	1	0	0
	Шимэгч судлал	1	1	1	1	0	1	0	0	1	0	0	1	1	0	0	1
	Ийлдэс судлал	0	0	0	0	0	0	0	1	0	1	0	0	0	0	0	0
	Бусад /төрөлжсөн мэргэжлээр нэмж болно/	4	4	2	3	2	4	0	2	4	3	3	4	2	2	0	10
	Бусад	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	4
	Бүгд	4	4	2	3	3	4	0	2	4	3	4	4	2	1	0	10
Бусад эмнэлгийн мэргэжилтэн	6	5	3	3	3	2	3	2	5	3	1	4	1	1	1	12	
Эмнэлгийн туслах ажилтан	7	8	3	5	2	5	7	8	5	10	5	8	3	3	1	17	
2022 онд ажиллсан орон тоо	27	26	14	22	18	18	21	22	21	27	24	29	13	8	7	103	
Батлагдсан орон тоо	27	26	14	22	18	18	21	22	21	31	24	29	13	8	7	108	

Нийт Зоонозын өвчин судлах байгууллагын хүний нөөцийг хүйсээр нь харьцуулж үзэхэд 68 хувь нь эмэгтэй, 32 хувь эрэгтэйчүүд буюу хүйсийн харьцаа 3:1 байна. Зоонозын өвчин судлалын салбарт 30-39 насны хүмүүс хамгийн өндөр буюу 36 хувийг эзэлж байгаа бол 61-ээс

дээш буюу тэтгэврийн насны хүмүүс 1 хувь буюу харьцангуй цөөн тоогоор ажиллаж байгаа нь энэ салбарт түлхүү залуу боловсон хүчний бүрэлдэхүүнтэй байгаа нь харагдаж байна (Зураг 3).


Зураг 3. Зоонозын өвчин судлах байгууллагын ажиллах хүч насны ангиллаар



Тус төвд 2022 оны байдлаар Анагаах ухааны доктор, дэд профессор 1, Анагаах ухааны доктор 1, Биологийн ухааны доктор 1, Мал эмнэлгийн ухааны доктор 1, анагаахын болон биологийн шинжлэх ухааны магистр 21 тус тус ажиллаж байна. Докторантурт 7, магистрантурт 7 эмч,

эмнэлгийн мэргэжилтэн тус тус суралцаж байна. Энэ онд үндэсний төвийн хэмжээнд шинээр шинжлэх ухааны магистр 1, Био-анагаах ухааны магистр 1 нийт 2 мэргэжилтэн магистрийн зэрэг хамгаалсан байна (Зураг 4).


Зураг 4. ЗӨСҮТ-ийн эрдмийн зэргийн үзүүлэлт сүүлийн таван жилийн байдлаар



2022 онд Зоонозын өвчин судлалын байгууллагаас эрдэм шинжилгээний илтгэл дотоодод 5, олон улсад 6, эрдэм шинжилгээний

өгүүлэл гадаадад 3, дотоодод 5-ыг тус тус хэлэлцүүлэв (Зураг 5).

Зураг 5. Эрдэм шинжилгээний ажлын тоон үзүүлэлт /сүүлийн 5 жилээр/



БҮЛЭГ ХОЁР. ЗООНОЗЫН ӨВЧНИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1. ЗООНОЗЫН ХАЛДВАРЫН ХҮНИЙ ӨВЧЛӨЛИЙН ДУУДЛАГА; 2022


Улсын хэмжээнд зоонозын 12 төрлийн өвчин 20 аймаг, Улаанбаатар хотод бүртгэгдэж, нийт 685 хүлээн авч хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Нийт бүртгэгдсэн дуудлагыг аймгаар харьцуулж үзэхэд баруун бүс, хангайн бүсүүдэд өндөр тархалттай, Төвийн бүсэд өвчлөл

харьцангуй бага, Зүүн бүсээс Дорнод аймагт тархалт өндөртэй байна. Нийт бүртгэгдсэн дуудлага Улаанбаатар хот болон Ховд аймагт өндөр 51-108 дуудлага бүртгэгдсэн бол Сүхбаатар аймагт дуудлага бүртгэгдээгүй байна.



2022 January

2022 December



2.1.1. ХАЛДВАРТ ӨВЧИН

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар 28 төрлийн 325,343 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10 000 хүн амд 954.1 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 250646 тохиолдлоор буюу 10 000 хүн амд ногдох өвчлөл 761.4-оор буурсан байна. 10 000 хүн амд ногдох

халдварт өвчнийг аймгуудаар харьцуулбал: Өмнөговь (2793.9), Говь-сүмбэр (1443.0), Дорноговь (1291.8), Говь-Алтай (1160.9), Дорнод (1039.9) аймгууд болон Улаанбаатар хотод (1153.5) байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс 85.8-1839.8 өндөр байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Халдварт өвчний тохиолдол нас баралт, төрлөөр


№	Халдварт өвчний төрөл	Өвчлөл			Нас баралт		
		2021 он	2022 он	Өсөлт/Бууралт	2021 он	2022 он	Өсөлт/Бууралт
1	Амьсгалын замын халдварт өвчин	2729	6142	3413	59	68	9
2	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	9340	10718	1378	9	7	-2
3	Гэдэсний халдварт өвчин	1063	3962	2899	0	1	1
4	Зоонозын халдварт өвчин	106	217	111	1	1	-
5	Цусаар дамжих халдварт өвчин	99	1991	92	0	2	2
6	Бусад халдварт өвчин	562652	304113	-258539	1998	147	-1851
7	Нийт	575989	325343	-250646	2068	225	-1842

Эх сурвалж: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2022 оны 12 сарын тоон мэдээлэл, ЗӨСҮТ-д бүртгэгдээгүй бусад зоонозын халдвар орсон тоогоор

Халдварт өвчний нас баралт

Улсын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар халдварт өвчний нас баралтын нийт 226 тохиолдол бүртгэгдсэнээс коронавируст халдвар (142), сүрьеэ (66), төрөлхийн тэмбүү (6), нярайн бактерт үжил (5), вируст гепатит (2), суулгалт халдвар (1), ХДХВ/ДОХ (1), менингококкт халдвар (2) хүмхаа (1) тохиолдол тус тус бүртгэгдсэн байна (Зураг 6).

Зураг 6. Халдварт өвчний нас баралт, төрлөөр




2.1.2. ЗООНОЗЫН ХАЛДВАРЫН ХҮНИЙ ӨВЧЛӨЛИЙН ДУУДЛАГА

Улсын хэмжээнд 2022 онд зоонозын өвчний 685 дуудлага хүлээн авснаас хачигт риккетсиоз 497 (72.6%), галзүүгийн эрсдэлд өртсөн 65 (9.5%), хачигт энцефалит 49 (7.2%), хачигт боррелиоз 35 (5.1%), денге цусархаг чичрэг 11 (1.6%),

тарваган тахал 6 (0.9%), бэтэг 6 (0.9%), листериоз 6 (0.9%), боом 5 (0.7%), хумхаа 3 (0.4%), бруцеллиоз 2 (0.3%), ям 1 (0.1%)-ийг тус тус эзэлж байна (Зураг 7).

Зураг 7. Зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол, 2022 он



Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол өмнөх оноос 1.2 дахин нэмэгдэж, сүүлийн 5 жилийн дунджаас 35 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ онд өмнөх онуудтай мөн адил хачгаар

дамжих халдварын дуудлага 85 хувийг эзэлж байна. Харин токсоплазмоз, ку чичрэг, татран, бабезиоз зэрэг өвчний сэжигтэй тохиолдлын дуудлага бүртгэгдээгүй байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Зоонозын халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын тоог харьцуулсан үзүүлэлт сүүлийн 5 жилээр


Зоонозын өвчин	2017	2018	2019	2020	2021	2022	5 жил дундаж
Тарваган тахал	8	7	7	22	4	6	9.6
Боом	12	10	9	4	5	5	8
Хачигт энцефалит	230	181	88	85	29	49	122.6
Хачигт боррелиоз	116	96	77	83	4	35	75.2
Хачигт риккетсиоз	929	822	676	860	218	497	701
Хумхаа	4	2	5	4	4	3	3.8
Галзуугийн эрсдэлд өртсөн	169	121	132	95	39	65	111.2
Денге чичрэг	3	1	5	0	-	11	1.8
Бэтэг	17	25	18	25	6	6	18.2
Токсоплазмоз	1	1	-	-	-	-	0.4
Ку чичрэг	-	1	1	-	-	-	0.4
Татран	-	1	-	-	-	-	0.2
Бруцеллёз	-	-	3	3	-	2	1.2
Ям	-	-	1	-	-	1	0.2
Бабезиоз	-	-	-	-	1	-	0.2
Листерииоз	-	-	-	-	-	6	0
Нийт	1489	1267	1022	1181	310	685	1053.8

2.2. МЭРЭГЧ АМЬТНЫ ДУУДЛАГА; 2022

2022 онд байдлаар хот орчмын зоонозын халдварт өвчний сэжигтэй амьтны дуудлага 208 удаа хүлээн авч 1428 нэгж материалын гарал үүслийг тодорхойлж лабораторийн шинжилгээнд хамруулж, тархвар судлалын холбогдолгүй болохыг тогтоож, хариуг утсаар болон албан бичгээр хүргүүлж ажиллалаа.


Өмнөх жилтэй харьцуулахад зоонозын халдварт өвчний сэжигтэй амьтны дуудлага 1.1 дахин өсөж, дуудлагаар шинжилсэн нэгж материал 2.2 дахин өссөн байна. Ковид-19 цар тахлын үед хязгаарлалтын дэглэмийн үед буюу 2020-2021 онд зорчих хөдөлгөөн бага байсан нь зоонозын халдварт өвчний сэжигтэй амьтны дуудлага буурахад нөлөөлсөн (Зураг 8).

Зураг 8. Мэрэгчийн дуудлага, нэгж материал (Сүүлийн 5 жилээр)



Зоонозын шалтгаант мэрэгч амьтны дуудлагын аймагтаар 0.5 хувь тус тус бүртгэгдсэн байна. Улаанбаатар хотод 82 хувь, тодорхойгүй 15 хувь, (Зураг 9). Төв аймагт 2 хувь, Говь-Алтай, Дорноговь


Зураг 9. Мэрэгчийн дуудлага, аймагаар, 2022 он.





2022 January

2022 December



2.3.1. ЗООНОЗЫН ХАЛДВАРЫН ХҮНИЙ ӨВЧЛӨЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Улсын хэмжээнд 2022 онд зоонозын өвчний сэжигтэй тохиолдлын 685 дуудлага бүртгэгдсэнээс 153 буюу 22 хувь нь лаборатори болон тархвар судлалаар онош батлагдсан байна. Энэ онд нийт 7 төрлийн өвчин батлагдсан бөгөөд нийт өвчлөлийн 80 хувийг хачигт риккетсиоз, 11 хувийг хачигт боррелиоз, 5 хувийг хачигт энцефалит, тарваган тахал, боом, хүмхээ, ям өвчнүүд тус тус 1 хувийг эзэлж байна.

Нийт батлагдсан өвчлөлийг аймгаар нь харьцуулж үзэхэд Дорнод аймагт 20-26 буюу хамгийн өндөр, Улаанбаатар хот, Хөвсгөл, Ховд, Завхан аймгуудад 15-19, Говь-Алтай, Архангай, Сэлэнгэ аймгуудад 7-14, Баян-Өлгий,

Өвөрхангай аймагт 4-6, Говь-Сүмбэр, Орхон, Сүхбаатар, Хэнтий аймгуудад өвчлөл бүртгэгдээгүй бол 1-3 тохиолдол бусад аймгуудад бүртгэгдсэн байна.

Зоонозын өвчний батлагдсан тохиолдлоос хачигт риккетсиоз 21 хувь нь Дорноговь аймагт, хачигт боррелиоз 37.5 хувь нь Завхан аймагт, хачигт энцефалит 75 хувь нь Сэлэнгэ аймагт хамгийн өндөр хувьтай бүргэгдсэн байгаа нь тус аймагт оршин сууж буй болон тухайн бүс нутгуудаар зорчиж буй хүн ам хачгаар дамжих халдвараар өвчлөх эрсдэлтэй байгаа нь харагдаж байна (Хүснэгт 6).


Хүснэгт 6. 2022 онд бүртгэгдсэн зоонозын өвчний төрлөөр, аймгаар

№	Аймаг	Тарваган тахал	Боом	Галзуу	Хачигт риккетсиоз	Хачигт энцефалит	Хачигт боррелиоз	Хумхаа	Бэтэг	ЯМ	Нийт
1	Архангай	0	0	0	13	0	1	0	0	0	14
2	Баян-Өлгий	0	0	0	2	0	0	0	0	0	2
3	Баянхонгор	0	0	0	2	0	1	0	0	0	3
4	Булган	0	0	0	1	0	0	0	0	0	1
5	Говь-Алтай	0	0	0	12	0	0	0	0	0	12
6	Говьсүмбэр	0	0	0	0	0	0	0	0	0	0
7	Дархан-Уул	0	0	0	0	1	0	0	0	0	1
8	Дорноговь	0	0	0	1	0	0	0	0	0	1
9	Дорнод	0	0	0	26	0	0	0	0	0	26
10	Дундговь	0	0	0	0	0	0	0	0	0	0
11	Завхан	0	0	0	13	0	6	0	0	0	19
12	Орхон	0	0	0	0	0	0	0	0	0	0
13	Өвөрхангай	0	0	0	6	0	0	0	0	0	6
14	Өмнөговь	0	0	0	2	0	0	0	0	0	2
15	Сүхбаатар	0	0	0	0	0	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	0	0	0	2	6	3	0	0	0	11
17	Төв	0	0	0	2	0	0	0	0	0	2
18	Увс	0	1	0	2	0	0	0	0	0	3
19	Ховд	2	0	0	11	0	2	0	0	0	15
20	Хөвсгөл	0	0	0	16	0	0	0	0	0	16
21	Хэнтий	0	0	0	0	0	0	0	0	0	0
22	Улаанбаатар	0	1	0	11	1	3	1	1	1	19
	Улсын дүн	2	2	0	122	8	16	1	0	1	153

Зоонозын өвчлөлийн сэжигтэй тохиолдлын дүүдлага сүүлийн 5 жилийн байдлаар 2018 онд хамгийн өндөр бүртгэгдэж, сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байсан бол хүний өвчлөл

өмнөх онд буурч, энэ онд өссөн байна. Харин нас баралтын түвшин сүүлийн жилтэй харьцуулахад ижил үзүүлэлттэй байна (Зураг 10).


Зураг 10. Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол, өвчлөл, нас баралт (сүүлийн 5 жилээр)



Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол, батлагдсан тохиолдлыг аймгаар харьцуулж үзэхэд сэжигтэй тохиолдол Ховд аймагт хамгийн өндөр 10,000 хүн амд өвчлөл 1.7 байгаа бол Дорнод аймагт сэжигтэй тохиолдлын 96% нь батлагдаж 10 000 хүн амд өвчлөл 3.1 буюу

хамгийн өндөр байна. Үүнээс харахад цаашид Дорнод аймагт ЗӨСТ байгуулж эрсдэлт бүлгийн хүн амыг зоонозын халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллах шаардлагатай байна (Зураг 11).

Зураг 11. Зоонозын өвчний сэжигтэй батлагдсан тохиолдол 10 000 хүн амд аймгаар



Хүснэгт 7. Зоонозын өвчлөл 10 000 хүн амд (Сүүлийн 5 жилээр)

Он	2017		2018		2019		2020		2021		2022		5 жил дундаж
	Б/тоо	10 000	Б/тоо	10 000	Б/тоо	10 000	Б/тоо	10 000	Б/тоо	10 000	Б/тоо	10 000	
Тарваган тахал/A20	1	0.0	0	0.0	2	0.0	6	0.0	1	0.0	2	0.0	2
Боом/A22	1	0.0	0	0.0	1	0.0	0	0.0	1	0.0	1	0.0	0.6
Хачигт энцефалит/A84	62	0.2	32	0.1	19	0.1	20	0.1	1	0.0	8	0.0	26.8
Хачигт боррелиоз/A69	46	0.1	24	0.1	17	0.1	13	0.0	5	0.0	16	0.0	21
Хачигт риккетсиоз/A77	357	1.1	203	0.6	139	0.4	182	0.5	60	0.2	122	0.4	188.2
Галзуу/A82	0	0.0	0	0.0	0	0.0	1	0.0	0	0.0	0	0.0	0.2
Хумхаа/B50	2	0.0	0	0.0	1	0.0	2	0.0	1	0.0	1	0.0	1.2
Барууннил /A92.3	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0
Денге чичрэг /A90	0	0.0	1	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0.2
Бэтэг /B67	17	0.1	25	0.1	4	0.0	4	0.0	1	0.0	1	0.0	10.2
Ям/ A24	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	1	0.0	0
Нийт	486	1.5	285	0.9	183	0.6	228	0.7	70	0.2	153	0.4	250.4

Б/Тоо-Бодит тоо, 10 000-10 000 хүн амд

2022 онд бүртгэгдсэн зоонозын өвчний өвчлөлийн түвшин 10,000 хүн амд 0.4 байгаа нь өмнөх оноос 1.2 дахин өссөн, 5 жилийн дундаас 61 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин өвчлөлийн тохиолдлыг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд хачигт

боррелиоз 3.2 дахин, хачигт риккетсиоз 2 дахин өссөн байна. Энэ онд шинээр ям өвчний тохиолдол 1 бүртгэгдсэн байна (Хүснэгт 7).


2.3.2. ТАРВАГАН ТАХАЛ

Тарваган тахлын хүний өвчлөлийн мэдээлэл

Монгол улсад 2022 оны байдлаар тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын 6 дүүдлага бүртгэгдсэний 2 буюу 33.3 хувь нь

батлагдаж, нас баралт бүртгэгдээгүй байна (Зураг 12).

Зураг 12. Тарваган тахлын хүний өвчлөл (сүүлийн 10 жилийн байдлаар)



Тарваган тахлын хүний өвчлөл 1970 оноос хойш Монгол улсад нийтдээ 216 тохиолдол бүртгэгдэж, нийт бүртгэгдсэн өвчлөлийн нас баралтын түвшин 39.3 байна. Тарваган тахал өвчний батлагдсан тохиолдлыг 10 жилээр нь харьцуулж үзэхэд 1990-1999 онд хамгийн өндөр

буюу нийт тохиолдлын 85, 39 хувь нь бүртгэгдэж, нас баралтын түвшин 47.1 хувьтай байна. Харин 2020-2022 байдлаар нийт 7 тохиолдол бүртгэгдэж, нас баралтын түвшин 50 хувьтай байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Тарваган тахлын батлагдсан тохиолдол, нас баралт, нас баралтын хувь (1970-2022 он)

Он	Тохиолдол	Нас баралт (бодит тоогоор)	Нас баралтын хувь
1970-1979	16	10	62.5
1980-1989	51	14	27.5
1990-1999	85	40	47.1
2000-2009	44	13	29.5
2010-2019	11	5	45.5
2020-2021	7	3	50
Нийт	21	85	39.9

2022 оны 9 сард Ховд аймагт Завхан тарваган тахлын хүний өвчлөлийн 2 тохиолдолын онош батлагдаж, 10,000 хүн амд өвчлөл 0.1 байна. Тарваган тахал сэжигтэй тохиолдлын дуудлага

өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар, өвчлөл 50 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Тарваган тахал өвчний өвчлөл, нас баралтын түвшин /2021-2022/


№	Аймаг	А 20 Тарваган тахал /A20				Нас баралт
		Өвчлөл		10 000 хүн амд		
		2021	2022	2021	2022	
1	Архангай	0	0	0	0	0
2	Баян-өлгий	0	0	0	0	0
3	Баянхонгор	0	0	0	0	0
4	Булган	0	0	0	0	0
5	Говь-Алтай	0	0	0	0	0
6	Говь-сүмбэр	0	0	0	0	0
7	Дархан-уул	0	0	0	0	0
8	Дорноговь	0	0	0	0	0
9	Дорнод	0	0	0	0	0
10	Дундговь	0	0	0	0	0
11	Завхан	1	0	0.1	0	0
12	Орхон	0	0	0	0	0
13	Өвөрхангай	0	0	0	0	0
14	Өмнөговь	0	0	0	0	0
15	Сүхбаатар	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	0	0	0	0	0
17	Төв	0	0	0	0	0
18	Увс	0	0	0	0	0
19	Ховд	0	2	0	0.2	0
20	Хөвсгөл	0	0	0	0	0
21	Хэнтий	0	0	0	0	0
Аймгийн дүн		1	2	0	0	0
22	Улаанбаатар	0	0	0	0	0
Улсын дүн		1	2	0	0	0

Тарваган тахлын байгалийн голомт


2022 онд ЗӨСҮТ болон ЗӨСТ нь тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээний төлөвлөгөөт ажлын хүрээнд улсын хэмжээнд голомтод аймгийн 82.3% (15), сумдын (63) 45.5%-ийг хамруулсан байна. Шинжилгээнд нийт 2,080,945 га талбайг хамруулж, 2829 мэрэгч

туулай хэлбэртэн, 230 зэм үхдэл, 2274 махчин шувуудын гүлгидас, 7279 гадны шимэгчийг цуглуулан шинжилж 3 аймгийн 6 сумын нутагт хамрагдах байгалийн голомтоос тарваган тахлын өсгөвөр 23, эерэг сорьц 41 тус тус илрүүлсэн байна (Зураг 13).

Зураг 13. Тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээнд хамрагдсан аймаг, сумдаар




Зураг 14. Тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээ



Монгол улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан бүс нутгийн тарваган тахал өвчний үндсэн болон дэд агуулагчийн нягтшил мэрэгч бүрт үзвэл: Монгол тарвага 1 га-д дунджаар 1.9, урт сүүлт зурам 1 га-д 3.4, огдой 1 га-д 4.3, үлийн цагаан


оготно 10.8 тус тус ноогдож байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 1 га дах мэрэгчийн нягтшил нь тарвага 0.6%-аар, зурам 0.8%-аар өссөн, харин огдой, үлийн цагаан оготны дундаж нягтшил 1 га-д 10.8 үзүүлэлттэй байна (Зураг 15).

Зураг 15. Мэрэгч амьтдын нягтшил 1 га-д




Тарваган тахлыг дамжуулагч болох бүүрэгний хувьд: Олзворлосон нийт мэрэгчийн үс ноолуурт бүүрэгний ноогдоц дунджаар – 2.7, тохиолдоц 34.3% - 66.2%, нүхний амсарт ноогдоц – 0.53%, тохиолдоц – 3.58%, ноохойн ноогдоц – 15.3%, тохиолдоц-72.1%-тай байна. Тарваган тахал

өвчнийг дамжуулагч бүүрэгний ерөнхий нөөц дунджаар тарвага 4.5, урт сүүлт зурам 9.5, чичүүлд 7.2, үлийн цагаан оготно 11.3 ноогдож өмнөх оноос 8-14%-аар өссөн байна (Зураг 16,17).



Зураг 16. Шинжилсэн гадны шимэгч



Зураг 17. Шинжилсэн мэрэгч

Үндсэн агуулагч Монгол тарваганы нягтшил нь газар нутаг бүр харилцан адилгүй алаг цоог тархалттай бөгөөд Увс, Ховд, Баян-Өлгий, Өвөрхангай, Баянхонгор аймгуудын шинжилгээ хийсэн зарим сумдад тоо толгой нь өсөх хандлагатай ба дунджаар 1га-д 2.9-4.6 ноогдож байна. Жижиг мэрэгчийн нягтшил хувьд: урт сүүлт зурам болон огдой нь өмнөх оноос өссөн, харин


үлийн цагаан огтоны хувьд Төв, Завхан, Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт 1 га-д дунджаар 7.1-31.7 нягтшилтай байна.

Тарваган тахлын байгалийн голомтын идэвхжил нь мэрэгчдийн нягтшил, халдвар дамжуулах идэвхтэй бүүрэгний тоошилтой шүүд хамаардаг бөгөөд тарваган тахлын өсгөвөр илрэлт болон

хүний өвчлөлийн тохиолдлын тоо хоорондоо шууд хамааралтай байдаг. 2022 онд тарваган тахлын өсгөвөр 95.7% тарваганы үхдэл, болон түүний эд, эрхтнээс, 4.3% нь урт сүүлт зурамны эрхтний булингаас илэрсэн байна (2021 онд тарваганы зэм үхдэлийн эд, эрхтэнээс 100% илэрсэн).

Шинжилгээний дүнд Монгол Алтай дэрлэгүүн голомтод хамаарах Баян-Өлгий, Ховд, Төвийн Алтайн дэрлэгүүн голомтод хамаарах Увс зэрэг 3 аймгийн 7 сумын 9 бичил голомтоос тарваган тахлын нян илэрч, 84,200 га талбай эпизооттой болохыг тогтоогоод байна (Зураг 18).

Зураг 18. Тарваган тахлын өсгөвөр илэрэлт (сүүлийн 10 жилээр)




Тарваган тахлын дархлаажуулалт

Тарваган тахлын голомтот нэмэгдэж идэвхжиж байгаатай холбоотой жил бүр хамрагдах хүний тоо нэмэгдэж байна. 2022 оны хувьд захиалгат вакцин нийлүүлэгдээгүй тул ХӨДББН-ийн вакцинаа ЭМС-ын тушаал, албан даалгаврын дагуу хийгдэхээр голомтот нутгууддаа тараасан.

Улсын хэмжээнд тарваган тахлын эсрэг вакциныг 2022 оны 07 дугаар сарын 05 ны өдрөөс 07 дугаар сарын 25-ны хугацаанд зохион байгуулан 13 аймгийн 111 сум, нийслэлийн 7 дүүрэгт 24600 хүн тун вакцин хүргүүлж, (хамралт 89.7%) хамрагдсан байна (Зураг 19).

Зураг 19. Тарваган тахлын дархлаажуулалт 2012-2022 он




2.3.3. БООМ

Боомын малын өвчлөлийн мэдээлэл


2022 оны эхний хагас жилийн байдлаар 5 Хэнтий, Хөвсгөл зэрэг аймгуудад тус тус аймгийн 8 суманд 9 голомтод 13 үхэр, 1 ямаа тус бүртгэгдсэн байна. Малын өвчлөл төрлөөр үхэр тус боом өвчлөл бүртгэгдсэн байна. Малын 13 (92.8%) ямаа 1 (7.1%) өвчилсөн байна (Зураг өвчлөлийг Баянхонгор, Өвөрхангай, Орхон, 20).

Зураг 20. Малын боом өвчний гаралт 2022 он эхний хагас жилээр



Хөвсгөл, Хэнтий аймагт боомын малын өвчлөл, давтамж өндөр үзүүлэлттэй байна (Зураг 21).

Зураг 21. Монгол улсад малын боом өвчний дархлаажуулалт 2022 он




Мэдээллийн эх сурвалж: Мал эмнэлэг үржлийн га

Боомын хүний өвчлөлийн хүлээн авсан дуудлага

2022 онд монгол улсад боомын хүний өвчлөлийн сэжигтэй дуудлага Баянхонгор 1, Дорнод 1, Увс-1, Улаанбаатар 2, нийт 5 дуудлага хүлээн авч лабораторийн шинжилгээ, тархвар судлалаар Увс аймгийн Улаангом сум,

Улаанбаатар хот ХӨСҮТ-д боомын хүний өвчлөлийн тохиолдол батлагдсан байна. Сүүлийн 5 жилд боомын хүний өвчлөлийн тохиолдол жилд 1-2 тохиолдол бүртгэгдэж өвчлөл буурсан үзүүлэлттэй байна (Зураг 22).

Зураг 22. Хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт сэжигтэй дуудлагын тоо (2018-2022)



Боомын хүний өвчлөлийн мэдээлэл

2022 онд боомын хүний дуудлага 5 хүлээн авч эмнэлгийн тусламж үзүүлсэн бөгөөд Увс аймаг, Улаанбаатар хот боомын хүний өвчлөлийн тохиол бүртгэгдсэнийг 100% эмчилж

эдгэрүүлсэн тавилан сайтай байлаа. ЗӨСТ шинжилгээнд сорьц авч нян судлал нян харах, ПГУ шинжилгээгээр онош батлагдсан байна (Зураг 23).


Зураг 23. Боомын хүний өвчлөлийн тохиолдол, нас баралт (2000-2022)



Боомын хүний өвчлөл сүүлийн 10 жил ийн байдлаар малын өвчлөлтэй харьцуулж үзэхэд 2015 онд малын өвчлөл хамгийн өндөр

бүртгэгдсэн бол 2013 онд хүний өвчлөл хамгийн өндөр бүртгэгдсэн байна (Зураг 24).

Зураг 24. Боомын хүн, малын өвчлөлийн тохиолдол (Сүүлийн 10 жилээр)




Боомын голомт, хяналтын шинжилгээ

ЭМС-ын 2017 оны А/160 тоот тушаал, ЗӨСҮТ-ийн 2017 оны А/54 тушаалыг үндэслэж боомын байгалийн голомт хяналтын болон тархвар судлалын заалтаар хийгдэх хяналтын шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна.

2022 оны календарчилсан төлөвлөгөөний дагуу 14 аймагт 50 сум 5 дүүрэгт 2625 сорьц цуглуулсан нь улсын дундаж 187.5 байна.

Хэнтий, Сэлэнгэ аймгуудад цуглуулсан сорьцын тоо дунджаас дээгүүр, Говь-Алтай, Увс аймгуудад цуглуулсан сорьцын тоо улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Нийт дээжилсэн сорьцыг 100% лабораторийн шинжилгээнд хамруулсан. Үүнээс Өвөрхангай аймгийн Хужирт сумын "Хадан гол" гэх газрын хөрснөөс боомын үүсгэгч болох *Bac.Anthraxis 2* өсгөврийг илрүүлсэн байна (Зураг 25) .

Зураг 25. Шинжилгээнд дээжилтсэн сорьцын тоо аймгаар



ДЭМБ-аас 10 мал амьтны өвчлөл бүртгэгдэхэд 1 өвчлөл гарах магадлалтай гэж үзэх бөгөөд, эсрэгээрээ 1 хүний тохиолдол бүртгэгдэхэд

малын дунд өвчлөл байх магадлалтай гэдэг үзэл баримтлал бий. Сүүлийн жилүүдэд хүн, малын өвчлөл харьцангуй буурсан байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Боомын хүний өвчлөл, нас баралтын түвшин /2021-2022/

	Аймаг	А 22 Боом өвчин /Anthrax				Нас баралт
		Өвчлөл		10,000 хүн амд		
		2021	2022	2021	2022	
1	Архангай	0	0	0	0	0
2	Баян-Өлгий	0	0	0	0	0
3	Баянхонгор	0	0	0	0	0
4	Булган	0	0	0	0	0
5	Говь-Алтай	0	0	0	0	0
6	Говьсүмбэр	0	0	0	0	0
7	Дархан-Уул	0	0	0	0	0
8	Дорноговь	0	0	0	0	0
9	Дорнод	0	0	0	0	0
10	Дундговь	0	0	0	0	0
11	Завхан	0	0	0	0	0
12	Орхон	0	0	0	0	0
13	Өвөрхангай	0	0	0	0	0
14	Өмнөговь	0	0	0	0	0
15	Сүхбаатар	0	0	0	0	0
16	Сэлэнгэ	0	0	0	0	0
17	Төв	0	0	0	0	0
18	Увс	1	1	0.1	0.1	0
19	Ховд	0	0	0	0	0
20	Хөвсгөл	0	0	0	0	0
21	Хэнтий	0	0	0	0	0
	Аймгийн дүн	1	1	0	0	0
22	Улаанбаатар	0	0	0	0	0
	Улсын дүн	1	2	0	0	0

2.3.4. ХАЧГААР ДАМЖИХ ХАЛДВАР

Хачгаар дамжих халдварын хүн, малын тандалт судалгаа

2022 онд 14 аймгийн 43 сумын 299 цэгт хачигт халдварын тандалт шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна. Өмнөх онтой харьцуулахад шинжилгээнд хамрагдсан аймгийн тоо 27

хувиар, сумын тоо 2.1 дахин, цэгт газрын тоо 53 хувиар, цуглуулсан хачгийн тоо 14 дахин өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт 11)


Хүснэгт 11. Хачгаар дамжих өвчний тандалт шинжилгээнд хамрагдсан байдал

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	5 жилийн дундаж харьцуулахад	Өмнөх онтой
Аймгийн тоо	12	15	14	13	11	14	7.69%↑	27.27%↑
Сумын тоо	33	46	46	41	20	43	15.59%↑	2.15 дахин ↑
Цэгт газрын тоо	161	213	209	206	195	299	51.77%↑	53.3%↑
Хачгийн тоо	8510	13460	5277	6658	1830	8072	12.94%↑	14 дахин↑

Шинжилгээнд ирүүлсэн хачгийн 55.15%-д хачигт риккетсиоз, 18.54%-д ку чичрэг, 7.04%-д бартонелл; 8.59%-д хачигт риккетсиоз бартонеллын, 58.87%-д ку чичрэг хачигт риккетсиозын хавсарсан халдварын үүсгэгчийн ДНХ тодорхойлогджээ. Шинжилгээнд ирүүлсэн *D.nuttalli* зүйлийн хачгийн 68.19%-ийг эм хүйсийн хачиг эзэлж байсан бөгөөд 96.5% нь бие

гүйцсэн, 85.37% нь цус сороогүй өлөн хачиг байна. *I.persulcatus* зүйлийн хачиг бүгд бие гүйцсэн, 54.49% эм, 87.54% нь цус сороогүй хачиг байв. *H.asiaticum* зүйлийн хачгийн 68.78% эм, бүгд бие гүйцсэн, 79% нь цус сороогүй хачиг байна. Ховд аймгийн ЗӨСТ орон нутагтаа молекул биологийн шинжилгээ хийж үр дүнд хүрсэн (Зураг 26).

Зураг 26. Тандалт судалгаанд хамрагдсан газрууд 2022 он



Хачгаар дамжих халдварт өвчний мэдээлэл

Улсын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн хачгаар дамжих халдварын сэжигтэй тохиолдол нийт 19 аймаг, нийслэлийн 71 сум, дүүрэгт 581 тохиолдол бүртгэгдсэн. Нийт бүртгэгдсэн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын үзүүлэлт өмнөх жилийн 251 үзүүлэлтээс 1.3 дахин өссөн, сүүлийн 5 жилийн дундаж 899 үзүүлэлтээс 65 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Мөн нийт дуудлагын 85 хувь нь (497) хачигт риккетсиоз, 8 хувь нь (49) хачигт энцефалит, 6 хувь нь (35) хачигт боррелиоз тус тус эзэлж байна (Хүснэгт 12).


Хүснэгт 12. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй дуудлага (төрлөөр)

Өвчний нэр	2017	2018	2019	2020	2021	Дундаж	2022
Хачигт энцефалит	230	181	88	100	29	125.6	49
Хачигт боррелиоз	116	96	77	119	4	82.4	35
Хачигт риккетсиоз	929	822	676	810	218	691	497
Бүгд	1275	1099	841	1029	251	899	581

2022 онд эпидемиологийн долоо хоногийн хувьд тохиолдлын тоо сүүлийн 5 жилийн

дундаж үзүүлэлтээс буурсан ч гарч болох доод босго үзүүлэлтээс өссөн байна (Зураг 27).

Зураг 27. Хачигт халдварын эпидемиологийн 7 хоног




Хачигт энцефалитын хүний өвчлөл

Улсын хэмжээнд хачигт энцефалит өвчний 49 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнээс 16 хувь буюу 8 тохиолдол батлагдсан байна. Нийт батлагдсан тохиолдлоос 75 хувь нь Сэлэнгэ аймагт, 12.5 хувь нь Дархан-Уул аймагт, 12.5 хувь нь Улаанбаатар

хотод тус тус бүртгэгдсэн байна. Үүнээс үзэхэд Сэлэнгэ аймаг нь хачигт энцефалитын халдварын голомтот бүс нутагт хамаарч байна (Зураг 28).

Зураг 28. Хачигт энцефалитийн хүний өвчлөлийн тархалт 2022 он



Нийт хачигт энцефалитаар өвчлөгчид 4, 6, 7-дугаар саруудад хачигт хазуулан халдвар авч, толгой өвдөх-63%, халуурах-75%, дагз хөших-50%, хоолны дуршил бүүрах-38% зэрэг шинж тэмдгүүд түгээмэл илэрч, халдварын нууц үеийн хугацаа 4.8 хоног байна.

Өвчлөгсдийн дундаж нас 40 (19-58 нас), хүйсийн хувьд 62.5% нь эрэгтэй, 37.5% нь эмэгтэйчүүд эзэлж байна. Энэ жил хачигт энцефалитийн хүний өвчлөлийн нас баралт бүртгэгдээгүй байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Хачигт энцефалит өвчний хүний өвчлөл, нас баралтын түвшин/2021-2022/

